

Маргааны товч

“Октагон солюшн” ХХК-аас “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 09/6786 дугаар шийдвэрийг хууль бус болохыг тогтоож, хүсэлт гаргасан Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний аманд 5000 м.кв газрыг ашиглах эрх олгосон шийдвэр гаргахыг даалгах, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/144 дүгээр тушаалын компанийн хүсэлт гаргасан газартай давхцалтай хэсгийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргаж, үндэслэлээ “ ... хуулийн дагуу холбогдох баримтуудыг бүрдүүлэн газар ашиглуулах хүсэлт гаргасныг ашиглуулахаас татгалзсан нь хууль бус, газрын давхцалтай гэсэн нь үндэслэлгүй, газар ашиглуулах хүсэлт гаргасан газартай давхцуулан гуравдагч этгээдэд газар олгосон нь үндэслэлгүй” гэж;

Хариуцагчаас “... нэхэмжлэгчийн газар ашиглах хүсэлт гаргасан газрын “Грейт биг план” ХХК эзэмшдэг бөгөөд Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасантай нийцэхгүй, дархан цаазат газарт аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах эрх олгох боломжгүй, нэхэмжлэгч компани нь аялал жуулчлалын бааз байгуулах зориулалтаар газар ашиглах эрх хүссэн нь хуульд нийцээгүй, мөн газар ашиглах эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох ба ямар хуулийг зөрчиж газар ашиглах эрх олгосон гэж тушаалыг хүчингүй болгуулахаар маргаж байгаа нь тодорхойгүй, тусгай хамгаалалттай газрыг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар шийдвэрлэхээр заасан” гэж;

Гуравдагч этгээдээс “... нэхэмжлэлийн шаардлага бодит байдалд хэрэгжих боломжгүй, бусдад олгосон газар дээр өөрсдөө дараа нь газар эзэмших хүсэлт гаргасан нь тогтоогдож байна, нэхэмжлэгчид сэргэх ашиг сонирхол байхгүй, тухайн үед маргах эрх байхад маргаагүй, хуульд заасны дагуу газар ашиглах эрхээ авснаас хойш гурвалсан гэрээ байгуулж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж, аялал жуулчлалын зориулалтаар ашиглахаар бусад этгээдтэй гэрээ байгуулаад, зардал хөрөнгө зарцуулсан ...” гэж тус тус тайлбарлан маргажээ.